



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 54

Мөрөн сум

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн жилийн үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын
тайлангийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор өгсөн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхийн өмнө аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчид боловсруулсан тайлангаа хянуулах, тайлангаар баталгаажсан дансны үлдэгдлийг компанийн бизнес төлөвлөгөөнд тодотголоор нэмэгдүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн зарцуулж байхыг компанийн гүйцэтгэх захирал (Г.Очирхуяг)-д, компанийн нягтлан бодогч шинээр томилогдсон бол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлж байхыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ц.Гансүх) нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ



6712020044



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 53

Мөрөн сум

“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн жилийн үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын
тайлангийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Хөвсөл Ус Суваг” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 09,10 дугаар тогтоолоор өгсөн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхийн өмнө аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчид боловсруулсан тайлангаа хянуулах, тайлангаар баталгаажсан дансны үлдэгдлийг компанийн бизнес төлөвлөгөөнд тодотголоор нэмэгдүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн зарцуулж байхыг компанийн гүйцэтгэх захирал (Ч.Батсүх)-д, компанийн нягтлан бодогч шинээр томилогдсон бол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлж байхыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хуншагай) нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ



65120200/2



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 55

Мөрөн сум

**“Шинэ Мөрөн худалдаа үйлчилгээний төв” ХХК-ийн
жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын
тайлангийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Шинэ Мөрөн худалдаа үйлчилгээний төв” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10, 11 дүгээр тогтоолоор өгсөн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг “Хэвийн” гэж дүгнэсүгэй.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхийн өмнө аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчид боловсруулсан тайлангаа хянуулах, тайлангаар баталгаажсан дансны үлдэгдлийг компанийн бизнес төлөвлөгөөнд тодотголоор нэмэгдүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн зарцуулж байхыг компанийн гүйцэтгэх захирал (Б.Баярмагнай)-д, компанийн нягтлан бодогч шинээр томилогдсон бол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлж байхыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Базардамбуу) нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ



6712020047



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 57

Мөрөн сум

“Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн жилийн үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлангийн
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.5, 8.6.8 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 08, 09 дугаар тогтоолоор өгсөн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг “Хэвийн” гэж дүгнэсүгэй.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхийн өмнө аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчид боловсруулсан тайлангаа хянуулах, тайлангаар баталгаажсан дансны үлдэгдлийг компанийн бизнес төлөвлөгөөнд тодотголоор нэмэгдүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн зарцуулж байхыг компанийн гүйцэтгэх захирал (Б.Амарбаясах)-д, компанийн нягтлан бодогч шинээр томилогдсон бол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлж байхыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Р.Машбат) нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ

6712020051